

# ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

## ИЛТГЭХ ХУУДАС

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2018 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН  
ХЭРЭГЖИЛТЭНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

2018.06.29

### НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн ерөнхий дүнг гаргахдаа арга хэмжээ, зүйл заалт бүрийн хэрэгжилтийн дунджаар тооцож, тавьсан зорилтын арга хэмжээ, шийдвэрийн зүйл заалтын гүйцэтгэлийн үр дүнг хүрэх түвшин буюу тавьсан зорилтод харьцуулж хувиар тооцсон

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн жилийн эцсийн хэрэгжилтэд Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг 3.2.1, 8.1 дэх заалтуудыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, журмын 6.3-д заасан аргачлалаар хэрэгжилтийн үнэлгээг тооцов.

Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн ерөнхий дүнг гаргахдаа арга хэмжээ, зүйл заалт бүрийн хэрэгжилтийн дунджаар тооцож, тавьсан зорилтын арга хэмжээ, шийдвэрийн зүйл заалтын гүйцэтгэлийн үр дүнг хүрэх түвшин буюу тавьсан зорилтод харьцуулж хувиар тооцсон.

### ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Үр дүнд суурилсан явцын үнэлгээ хийх нь баримт бичгийн хэрэгжилт зорилтод түвшинд хүрч байгаа эсэхэд үнэлгээ хийж, хүрээгүй тохиолдолд шалтгаан нөхцлийг тодорхойлж, үр дүнг сайжруулахад чиглэгддэг. Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн 74 тогтоолын 112 арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 69,0 хувийн гүйцэтгэлтэйгээр үнэллээ: Үүнд:

- Бүрэн хэрэгжсэн буюу 100 хувьтай 27
- Хэрэгжих шатандаа буюу 70 хувьтай 60
- Хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувьтай 23
- Хэрэгжээгүй буюу 0 хувьтай 1
- Хэрэгжилтийн хугацаа тооцох болоогүй 1

Тайлангаас зорилтод түвшиндээ хүрч бүрэн хэрэгжсэн, үйл ажиллагаа тогтмолсон 8 арга хэмжээний 70 хувьтай үнэлгээг 100 хувь болгон өсгөж үнэлсэн.

Үнэлгээ бууруулсан арга хэмжээнүүд:

1. МУ-ын хуулийн 27.4 –ийн хэрэгжилтийн 100 хувьтай үнэлгээг орон нутгийн чанартай авто замын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх, мэдээлэх журмыг батлуулаагүй байгаа урчаас шалгуур үзүүлэлтэд дүйцүүлж 70 хувь болгон бууруулсан.

2. Үндэсний хөтөлбөр батлах тухай /Жендэр/ 2017-04-26 Дугаар 2017\_129 -3 хэрэгжилтийг 70 хувьтай үнэлгээг хэрэгжүүлэх арга хэмжээндээ хүрээгүй, үр дүн гараагүй гэж үзэн үнэлгээг 30 хувь болгон бууруулсан.

3. Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого батлах тухай 2017-09-27 Дугаар 2017\_295 -48 хэрэгжилтийг Үнэлэх боломжгүй үнэлгээг тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх төлөвлөсөн, зохион байгуулалтын арга хэмжээ авагдаагүй байгаа учраас хэрэгжээгүй 0 болгон бууруулсан.

Хэлтсүүд тайлан бичихдээ арга хэмжээг зорилтод түдшиндээ дүйцүүлж тайлагнаагүй, тоон мэдээлэл дутуу, зорилтод түвшингээ, хүрсэн түвшиндээ харьцуулаагүй нь үнэлгээг бууруулах нөхцөл болсон.

## **ГУРАВ. ДҮГНЭЛТ**

Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хүрээнд 2018 оны хагас жилийн байдлаар 74 тогтоол шийдвэрийн 112 зүйл заалтыг хяналтанд авч эзэнжүүлэн хэрэгжилтийн ерөнхий дүнг гаргахдаа арга хэмжээ, зүйл заалт бүрийн хэрэгжилтийн дунджаар, тавьсан зорилтын арга хэмжээ, шийдвэрийн зүйл заалтын гүйцэтгэлийн үр дүнг хүрэх түвшин буюу тавьсан зорилтод харьцуулж 73,18 хувийн биелэлттэй үнэллээ.

Хагас жилийн байдлаар бүрэн хэрэгжсэн буюу үйл ажиллагаа тогтмолжсон нийт 14 тогтоол шийдвэрийн 19 арга хэмжээг ЗГХЭГМС-ээс хасуулж, үүнээс 7 тогтоол шийдвэрийг дотоод хяналтанд үлдээж, хангалтгүй буюу 30 хувьтай хэрэгжсэн 23, хэрэгжээгүй 1 тогтоол шийдвэрийг эрчимжүүлж, сарын төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангах ажиллах нь зүйтэй.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж хурлын тэмдэглэлийг цаасан тайланд хавсаргаж ЗГХЭГ-т хүргүүлэх

## **ДӨРӨВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ / ЗӨВЛӨМЖ /**

Хяналтанд өгсөн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэхдээ хэлтсүүд харьяа агентлагуудын жил, сарын төлөвлөгөөнд тусгуулж, хэрэгжүүлэх арга хэмжээг зөв тодорхойлох, тайлагнахдаа зорилтод түвшинд дүйцүүлж арга хэмжээний явцыг бус үр дүнг бичих нь чухал байна. Удаашралтай байгаа зүйл заалтыг хяналтанд авч эрчимжүүлж ажиллахаар зөвлөж байна.

ХЯНАСАН:

ХШҮДАХ-ИЙН ДАРГА

Х.БУЯНБАЯР

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:

ХШҮДАХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

П.НАРАНМАНДАХ

